

Огноо 2017 оны 4-р сарын 28 № 17/001


Улаанбаатар

ТАЙЛАН, ТӨСӨЛ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9 дэх заалт, 2017 оны 4-р сарын 28-ны өдрийн тооллогын комиссын 17/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн 2017 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бизнес төлөвлөгөө, төслийг батлан зөвшөөрсүгэй.
3. Нэмж хувьцаа гаргах нөхцөл бүрдсэн үед энэхүү хурлаар танилцуулагдсан үнэт цаасны танилцууллага болон холбогдох дүгнэлтүүдийг батлахыг ТУЗ-д үүрэг болгосугай.

ХМЭЛТЭН ДАРГА**Г.ОЮУНБОЛД**



Улаанбаатар

НЭМЖ ХУВЬЦАА ГАРГАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62.1.3, 32.5 заалтууд, 2017 оны 4-р сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын ...17/02... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Фронтнер Лэнд Групп” ХК нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлэх, хувьцааныхаа төвлөрлийг сааруулах зорилгоор 10 тэрбум төгрөг хүртлэх үнийн дүн, түүнд тохирох тооны энгийн хувьцаа нэмж гаргахыг зөвшөөрсүгэй.
2. Хувьцаа нэмж гаргаж байгаатай холбогдуулан компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулан, хувьцааны нэрлэсэн үнийг буулгах арга хэмжээнүүдээ аль тохирохыг нь авч хэрэгжүүлсний дараа нэмж хувьцаа гарган ажиллахыг ТУЗ-д үүрэг болгосугай.
3. 10 тэрбум төгрөг хүртлэх үнийн дүн, түүнд тохирох тооны энгийн хувьцааг нэмж гаргах шийдвэрийг Монголын Хөрөнгийн Бирж ХК, Санхүүгийн Зохицуулах Хороо хянан зөвшөөрсөний дараа компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.

ХУРЛЫН ДАРГА  Г.ОЮУНБОЛД



Огноо 2017.04.28


№ 17/003

Улаанбаатар

КОМПАНИЙН ДҮРЭМД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.1 дэх заалт, 2017 оны 4-р сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын17/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор 10 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүнд тохирох энгийн хувьцааг нэмж гарган уг шийдвэрийг “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК болон Санхүүгийн Зохицуулах Хороо хянан зөвшөөрсний дараа компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсугай.
2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 10 тэрбум хүртэлх төгрөгөөр нэмэгдүүлсүгэй.
3. Компанийн үйл ажиллагааны чиглэлд үл хөдлөх хөрөнгө, үл хөдлөх хөрөнгийн худалдаа, түрээс, зуучлал, үл хөдлөх хөрөнгийн менежмент гэх зэрэг үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой хуулиар зөвшөөрсөн, тусгай зөвшөөрөл шаардагдахгүй үйл ажиллагаануудыг нэмэх, холбогдох тогтоолыг гаргах эрхийг ТУЗ-д олгосугай.
4. Компанийн хувьцаатай холбоотой нэрлэсэн үнэ, хувьцааны тоо зэрэг асуудлууд болон компанийн шинэчилсэн дүрмийг бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх Захиралд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Г.ОЮУНБОЛД



Огноо 2017.04.28

№ 17/004

Улаанбаатар

**ТЭРГҮҮН ЭЭЛЖИНД ХУВЬЦАА
ХУДАЛДАН АВАХ ЭРХ ЭДЛҮҮЛЭХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 38-р зүйл, 2017 оны 4-р сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын ...17/02... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь компаниас нэмж хувьцаа гаргасан тохиолдолд өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тодорхой нөхцөлөөр нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй болохыг дурдсугай.
2. Компанийн нэмж гаргах гэж буй хувьцааг Компанийн тухай хуулийн 38-р зүйлд заасны дагуу тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхийг одоогийн хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэхээр шийдвэрлэсүгэй.
3. Хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах үнийг тухайн үед нь тогтоохыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.
4. Санхүүгийн зохицуулах хороо нэмж хувьцаа гаргахыг зөвшөөрсөн тохиолдолд хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах журам, мэдэгдэлийг энгийн хувьцаа эзэмшигч бүрт хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэдэг журмаар хүргүүлэхийг компанийн Гүйцэтгэх Захирал-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ОЮУНБОЛД

Огноо 2017.04.28

№ 17/005

Улаанбаатар

ШААРДАХ ЭРХ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлүүд 2017 оны 4-р сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 17/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компани нэмж хувьцаа гаргах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож амжаагүй эсвэл хурлаас гаргасан нэмж хувьцаа гаргах шийдвэртэй санал нийлэхгүй байгаа хувьцаа эзэмшигчид Компаний тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу компанид хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрх үүссэн гэдгийг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.
2. Хувьцаагаа эргүүлэн Компанид зарах хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийн хувьцааг эргүүлэн худалдан авах журмыг Санхүүгийн Зохицуулах Хорооноос шийдвэр гарсаны дараа боловсруулан хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалан ажиллахыг ТУЗ-д үүрэг болгосугай.
3. Компани хувьцааг буцаан худалдан авсны дараа төлбөрийн чадвартай үлдэх ёстой гэдгийг санан буцаан худалдан авах үнийг тогтоон энэхүү ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ОЮУНБОЛД

Огноо 2017.04.28

№ 12/006

Улаанбаатар

КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7 заалт, 2017 оны 4-р сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 17/6 хугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий зургаан хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

1. Эльёр Хасанов
2. Г.Оюунболд
3. Б.Өлзийбаяр
4. М.Төвшин
5. Камалиддин Талипов
6. Д.Батсайхан

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий гурван хүнийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

1. Д.Үнэнбат
2. С.Батбилэг
3. Ц.Мэндбаяр

3. Компанийн тухай хууль болон дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ОЮУНБОЛД

Огноо 2017.04.28

№ 17/007

Улаанбаатар

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ЗАРДЛЫН ТӨСӨВ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.13 дахь заалт, 2017 оны 4-р сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын17/02... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Фронтьер Лэнд Групп” ХК-ийн 2017 оны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны төсөв, гишүүдийн цалинг хавсралтын дагуу баталсугай.
2. Батлагдсан төсвийн дагуу ажиллахыг эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

ХУРЛЫН САРГА



Г.ОЮУНБОЛД

Огноо 2017.04.28

№ 17/008

Улаанбаатар

Компанийн тухай хуулийн холбогдох заалт, 2017 оны 4-р сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын17/02..... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компани болон анхны үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан Туул сонгино усны нөөц цогцолбор төслийг хэрэгжүүлэх гэрээний хугацаа дуусгавар болж байгаа тул хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс гэрээг шинэчлэн байгуулсугай.
2. Газар эзэмших гэрчилгээний эрхийн хугацаа сунгагдах үед уг гэрээг шинэчлэн байгуулах ба гэрээ нь дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурал хүртэл хүчин төгөлдөр байна.
3. Шинэчилсэн гэрээг хавсралтын дагуу баталсугай.
4. Батлагдсан гэрээний дагуу анхны үүсгэн байгуулагч нартай гэрээ байгуулан, гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах тал дээр идэвхи чармайлт гарган ажиллахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ОЮУНБОЛД

Огноо 2017.09.28

№ 17/009

Улаанбаатар

**НОГДОЛ АШИГ ХУВИАРЛАХГҮЙ ТУХАЙ
ШИЙДВЭРИЙГ ТАЙЛАГНАХ НЬ:**

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.6-р заалтууд, 2017 оны 4-р сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын 17/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тус компани нь ногдол ашиг хувиарлахгүй гэж шийдвэрлэсэн тухай болон түүний үндэслэл тайлбарыг хувьцаа эзэмшигч нарт тайлагнасан болохыг дурьдсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ОЮУНБОЛД